



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/613

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 82 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Буянт, Жаргалант сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургууль, "Хөгжил" политехник коллежийн дотуур байранд 4 нэр төрлийн 580 ширхэг зөөлөн эдлэл шинэчлэх зардалд 16 675 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 16 675 000 төгрөг /арван зургаан сая зургаан зуун далан таван мянга/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс тооцож гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ